



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 8 сарын 27 өдөр

Дугаар 330

Улаанбаатар хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн,
удирдамж батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн 8.1.16 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэршил, ангилал, бүртгэлийн журам боловсруулж, эрүүл мэндийн байгууллагуудын хөрөнгийн бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд ашиглах бүртгэлийн программ хангамж нэвтрүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамжийг нэгдүгээр, “Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, худалдах, импортлох, ханган нийлүүлэх байгууллагад тавигдах шаардлага” стандартыг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус баталсугай.

2.Ажлын хэсгийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган, үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж удирдамжийн дагуу ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /Р.Оюунханд/-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Ганчимэг/-д даалгасугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбоотойгоор Эрүүл мэндийн сайдын 2014 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 397 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.


САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

081162

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 11 сарын 27 өдрийн
330 дугаар тушаалын 1 дүгээр
Хавсралт



ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН НЭРШИЛ,
АНГИЛАЛ, БҮРТГЭЛИЙН ЖУРАМ БОЛОВСРУУЛАХ, БҮРТГЭЛИЙН
ПРОГРАММ ХАНГАМЖ НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн дарга: Р.Оюунханд, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
- Нарийн бичгийн дарга: Б.Сансармаа, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Санхүү эдийн засгийн хэлтсийн Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
- Гишүүд:
- М.Насанбаян, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
- С.Солонго, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Мэдээллийн технологи, эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны дарга
- Б.Батцоож, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Мэдээллийн технологи, эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, мэдээлэл, судалгааны нэгдсэн сан хариуцсан мэргэжилтэн
- Ж.Эрдэнэ-Очир, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Мэдээллийн технологи эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны салбарын цахимсан, програм хангамж хариуцсан мэргэжилтэн
- Б.Энхжаргал, Эрүүл мэндийн спортын яамны Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэргэжлийн салбар зөвлөлийн дарга
- Ж.Баярмаа, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын хяналтын улсын ахлах байцаагч /зөвшилцсөнөөр/

А.Баяр, Азийн хөгжлийн банк, Эрүүл мэндийн салбар хөгжил хөтөлбөрийн V төслийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн үндэсний зөвлөх /зөвшилцсөнөөр/

Ж.Баяртогтох, Азийн хөгжлийн банк, Эрүүл мэндийн салбар Хөгжил хөтөлбөрийн V төслийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

С.Баяржаргал, Стандартчилал хэмжил зүйн газрын Хэмжил зүйн хэлтсийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

М.Баярмаа, Нийслэлийн эрүүл мэндийн газрын Тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Д.Пүрэвдаш, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Эрчим хүчний сургуулийн багш /зөвшилцсөнөөр/

Т.Хүрэлчулуун, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Зөвлөх инженер

Ц.Сэргэлэн, Худалдан авах ажиллагааны газрын ААГ-ын мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

Б.Пүрэвцэцэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн тасгийн эрхлэгч

Н.Наранбаатар, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн тасгийн эрхлэгч

С.Учрал, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер

Г.Цэнгэл, Улсын гуравдугаар төв эмнэлгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн тасгийн эрхлэгч

**ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН НЭРШИЛ,
АНГИЛАЛ, БҮРТГЭЛИЙН ЖУРАМ БОЛОВСРУУЛАХ, БҮРТГЭЛИЙН
ПРОГРАММ ХАНГАМЖ НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ**

Үндэслэл:

Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний “Эрүүл чийрэг монгол хүн” хөтөлбөрийн 165 дугаар “Эх орондоо чанартай оношилгоо, эмчилгээ хийлгэх боломжийг бүрдүүлэх” зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд оношилгоо, эмчилгээний чанарын стандартыг шинэчилж, эрүүл мэндийн технологийн нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу “Эрүүл мэндийн технологийн нэгдсэн бодлого”-ыг Эрүүл мэндийн сайдын 2013 оны 176 дугаар тушаалаар батлуулсан.

Тус бодлогын 5.5 дугаар зүйлд мэдээллийн программ хангамжид түшиглэж эрүүл мэндийн салбарт үндэсний хэмжээний хөрөнгийн бүртгэлийн тогтолцоог бий болгох, 5.8 дугаар зүйлд эмнэлгийн тоног төхөөрөмжийг олон улсад өргөн ашиглагддаг ангилал, зэрэглэлийг мөрдлөг болгон эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн нэршил ангилалыг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх хэмээн тус тус заасан.

2014 оны байдлаар эрүүл мэндийн салбарт эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн нэгдсэн сан, бүртгэлийн журам байхгүй, нэр томъёо, ангилал байхгүйгээс нэг тоног төхөөрөмжийг маш олон нэршлээр нэрлэдэг, судалгаа шинжилгээ, статистик тоо баримт хангалтгүй, тоног төхөөрөмжийн эрэлт хэрэгцээг тогтоох, хянах, мэдээлэх, хөрөнгө төлөвлөх тогтолцоо бүрдээгүй байгаа нь эмнэлгийн тоног төхөөрөмжийг нэгдсэн бүртгэлийн журамыг боловсруулах үндэслэл болж байна.

Зорилго:

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэршил, ангилал болон бүртгэлийн журам боловсруулж, эрүүл мэндийн байгууллагуудын хөрөнгийн бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд ашиглах бүртгэлийн программ хангамж нэвтрүүлэх

Зорилт 1-ийн хүрээнд. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэршил, ангилалыг боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэршил, ангилал, бүртгэлийн журам, бүртгэлийн программ хангамж нэвтрүүлэх ажлын календарчилсан төлөвлөгөө гаргах
- Олон улсын эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэгдсэн нэршлийн “UMDNS” системийг монгол хэл дээр хөрвүүлэх, хянах
- Эрүүл мэндийн салбарт хэрэглэгдэх эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэршлийг UMDNS системтэй дүйцүүлж, нэгдсэн нэршил, ангилал боловсруулах
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэршил, ангилалын гарын авлага боловсруулж, сургалт зохион байгуулж, хэрэглээнд нэвтрүүлэх, хэвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

Зорилт 2-ийн хүрээнд. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэгдсэн бүртгэлийн журам боловсруулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Салбарын хэмжээнд эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэгдсэн нэршил, бүртгэлтэй болох эрх зүйн орчныг бүрдүүлэхэд шаардагдах “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэгдсэн бүртгэлийн журам” боловсруулах
- Журмын дагуу эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээний нэгдсэн сан бий болгох үйл ажиллагааг зохион байгуулах

Зорилт 3-ийн хүрээнд: Эрүүл мэндийн байгууллагуудын хөрөнгийн бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд ашиглах бүртгэлийн программ хангамж нэвтрүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Эрүүл мэндийн байгууллагуудын хөрөнгийн бүртгэлийн нэгдсэн тогтолцоондаашиглах бүртгэлийн программ хангамжийн ажлын даалгавар боловсруулах
- Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцооны үйл ажиллагааг зохицуулах зөвлөлтэй хамтран бүртгэлийн программ хангамжийг хүлээн авч, ашиглалтад оруулах
- Хөрөнгийн бүртгэлийн программ хангамжийн нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хянах

Хамрах хүрээ: Эрүүл мэндийн салбарын бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагууд

Хугацаа: 2015 -2016 он

Ажиллах бүрэлдэхүүн: Ажлын хэсэг

Зохион байгуулагч: Эрүүл мэнд, спортын яам, СБТГ, СЭЗХ

Санхүүжилт: АХБ, Эрүүл мэндийн салбар хөгжил хөтөлбөр – IV төсөл

Хүрэх үр дүн:

- Эрүүл мэндийн салбарт хэрэглэгдэж буй тоног төхөөрөмжүүд нэгдсэн нэршил, ангилалтай болно.
- “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэгдсэн бүртгэлийн журам” –тай болно.
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай болж, үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны... сарын 27 өдрийн
330 дугаар тушаалын 2 дугаар
Хавсралт

**“ЭМНЭЛГИЙН БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ, ПРОТЕЗ
ҮЙЛДВЭРЛЭХ, ХУДАЛДАХ, ИМПОРТЛОХ, ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ
БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА” СТАНДАРТЫГ
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Р.Оюунханд, Стратегийн бодлого, төлөвлөлтийн
газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Б.Сансармаа, Стратегийн бодлого, төлөвлөлтийн
газрын Санхүү эдийн засгийн хэлтсийн Тоног
төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын
төлөвлөлт, хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан
мэргэжилтэн

Гишүүд:

Ц.Ганбаатар, Стратегийн бодлого, төлөвлөлтийн
газрын Эрүүл мэндийн техник, технологийн
Бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

О.Оюунчимэг, Төрийн захиргаа удирдлагын
газрын Эм хангамжийн байгууллагын тусгай
Зөвшөөрлийн бодлогын хэрэгжилтийн
Зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Б.Энхжаргал, Эрүүл мэнд, спортын яамны
Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэргэжлийн
салбар зөвлөлийн дарга

Ж.Баярмаа, Мэргэжлийн хяналтын ерөнхий
газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний
чанар, аюулгүй байдлын хяналтын улсын
ахлах байцаагч /зөвшилцсөнөөр/

А.Баяр, Азийн хөгжлийн банк, Эрүүл мэндийн
салбар хөгжил хөтөлбөрийн V төслийн
Эмнэлгийн тоног төхөөрөмжийн үндэсний
зөвлөх/зөвшилцсөнөөр/

С.Баяржаргал, Стандартчилал хэмжил зүйн
газрын Хэмжил Зүйн хэлтсийн мэргэжилтэн
/зөвшилцсөнөөр/

М.Баярмаа, Нийслэлийн эрүүл мэндийн газрын
Тоног төхөөрөмж, төлөвлөлт хангалт хариуцсан
мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

Д.Пүрэвдаш, Шинжлэх ухаан технологийн их
сургуулийн Эрчим хүчний сургуулийн багш

Т.Хүрэлчулуун, Гэмтэл согог судлал үндэсний
төвийн Зөвлөх инженер

Б.Пүрэвцэцэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн
үндэсний төвийн Эмнэлгийн тоног
төхөөрөмжийн тасгийн эрхлэгч

Н.Наранбаатар, Халдварт өвчин судлалын
үндэсний төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн
тасгийн эрхлэгч

**“ЭМНЭЛГИЙН БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ, ПРОТЕЗ
ҮЙЛДВЭРЛЭХ, ХУДАЛДАХ, ИМПОРТЛОХ, ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ
БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА” СТАНДАРТЫГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН
УДИРДАМЖ**

Үндэслэл:

Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөөний (2006-2015) стратегийн 13-т “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, удирдамж, шалгуур үзүүлэлтийг оновчтой болгох”, Монгол улсын Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоол 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө “Эрүүл чийрэг Монгол хүн” зорилтын 8.1-д “төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгох болон магадлан итгэмжлэлийн шалгууруудыг шинэчлэн боловсруулна” гэж заасан байдаг.

Одоогийн эрх зүйн зохицуулалтаар эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез импортлох, худалдах, ханган нийлүүлэх чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 143, 145 дугаар тушаалын дагуу тусгай зөвшөөрөл олгож ирсэн.

Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез импортлох, худалдах, ханган нийлүүлэх чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад тавигдах шаардлагыг стандарт болгон батлах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Зорилго:

Эмнэлгийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэх байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг оновчтой болгох, оношилгоо, эмчилгээний техник, тоног төхөөрөмжийн хангамж, ашиглалт, засвар үйлчилгээний чанар, баталгаажилтыг сайжруулах

Зорилт:

1. “Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, худалдах, импортлох, ханган нийлүүлэх байгууллагад тавигдах шаардлага” стандартын төслийг боловсруулах
2. Стандартын төслийг аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн байгууллагууд, ЭМЯ-ны холбогдох мэргэжлийн салбар зөвлөл болон бусад байгууллагууд оролцсон уулзалтаар хэлэлцүүлэн санал авч эцэслэн боловсруулах.
3. Стандартын төслийг ЭМЯ-ны эрүүл мэндийн стандартын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэх
4. Стандартыг Стандартчилал, хэмжил зүйн газрын стандартын үндэсний зөвлөлийн хурлаар батлуулах

Хамрах хүрээ: Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, худалдах, импортлох, ханган нийлүүлэх байгууллагууд

Хугацаа: 2015 оны IV улирал

Ажиллах бүрэлдэхүүн: Ажлын хэсэг

Зохион байгуулагч: Эрүүл мэнд, спортын яам,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар,
Стандартчилал хэмжил зүйн газар

Хүрэх үр дүн: “Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, худалдах, импортлох, ханган нийлүүлэх байгууллагад тавигдах шаардлага” стандарт боловсрогдсон, батлагдана.